


Манай орны 7 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 15°C (53.6°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +21.1°C (64.6°F) –аас +28°C (77°F), бусад нутгаар 15.1°C –аас +21°C (53.8°F –аас 64.4°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 7 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 28 хувь нь ордог. Тус сард төвийн болон нутгийн хойд хэсгээр 80.1-140 мм, говь-цөлийн бүс нутгаар 5-40 мм бусад нутгаар 40.1-80 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2025 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -0.6°C-аар хүйтэн, ОЖД-аас 1.1°C-аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 8 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 69.0% нь дунджаас 1.0-ээс 3.0°C-аар дулаан, 30.2% нь дунджийн орчим, 0.8% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 47.3 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 26%-иар, ОЖД-аас 7.9%-иар тус тус бага байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 27 дахь бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 65.9% нь дунджаас бага, 23.3% нь дунджаас ахиу, 10.8% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2025 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 7 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) ихэнх хугацаанд нийт нутгаар ОЖД-аас 0.2°C -ээс 6.7°C -ээр дулаан, харин 1 дүгээр 10 хоногт баруун, өмнө, 2 дугаар хоногт зүүн, 3 дугаар 10 хоногт ихэнх нутгаар ОЖД-аас -0.3°C -ээс -4.6°C -ээр хүйтэн байсан байна. Хур тунадасны хувьд өмнө болон баруун зүгийн нутгаар хур тунадас бага, харин зүүн зүгийн нутгаар сарын турш харьцангуй ахиу тунадас оржээ.




Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Агаарын үнэмлэхүй их температур 30°C -ыг давж халсан өдөр Говь-Алтайн Тоорой, Баянхонгорын Шинэжинст сум Эхийнгол, Өмнөговийн Ханбогд, Дорноговийн Хөвсгөл, Замын-Үүд, Сайншанд орчмоор 25-30 өдөр, Өмнөговийн Сайхан, Манлай, Цогт-Овоо, Дорноговийн Эрдэнэ, Дундговийн Сайхан-Овоо, Гурвансайхан, Говь-Алтайн Ажбогд, Ховдын Зэрэг, Өвөрхангайн Баруунбаян-Улаан орчмоор 20-24 өдөр, бусад нутгаар 20-оос цөөн өдөр ажиглагджээ.



Зураг 4. 30°C -аас халуун өдрийн өдрийн тооны газарзүйн тархалт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 41.3°C , үнэмлэхүй бага утга Хөвсгөлийн аймгийн Цэцэрлэг/Чандагат өртөө/ суманд -1.2°C хүрсэн. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Улаанбаатар хотод 68°C , үнэмлэхүй бага утга Хөвсгөлийн аймгийн Цэцэрлэг суманд -3°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Хэнтий аймгийн Баян-Овоо суманд 9-ны өдөр 66.6 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 942.5гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 766.6гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Төв аймгийн Эрдэнэсант суманд 33м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд